2019 оны 05 сарын 14-ний өдөр Дугаар А/442 Улаанбаатар хот

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит
тооллогын бэлтгэл ажлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “г”, 29.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Хүн ам, орон сууцны тооллогын улсын комиссын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 23/15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах Нийслэлийн тооллогын түр товчооны бүрэлдэхүүнийг Нийслэлийн Статистикийн газрын бүтцийн хүрээнд байгуулсугай.

2.“Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого”-ыг зохион байгуулж явуулах үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, Нийслэлийн тооллогын комиссын гишүүдийн хариуцан ажиллах ажил үүргийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Нийслэлийн Тооллогын комиссын гишүүд хариуцан ажиллах ажил үүргийн хуваарийн дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллахыг даалгасугай.

4. Дүүргүүдийн Тооллогын комиссын дарга нарт дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг даалгасугай.

4.1.Дүүргийн болон хорооны түр товчоог байгуулж ажиллуулах;

4.2.“Хүн ам, орон сууцны тооллогыг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө”-ний дагуу бэлтгэл ажлыг сайтар хангах, “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-гийн алдааг засаж, баяжилт хийх ажилд онцгой анхаарах.

5.“Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого”-ын бэлтгэл ажлыг хангахад шаардагдах хөрөнгийг Нийслэлийн 2019 оны төсөвт тусгасан Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын бэлтгэл ажлыг хангах зардлаас санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т зөвшөөрсүгэй.

6. Нийслэлийн нутаг дэвсгэрт “Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого”-ыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаад даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ С.АМАРСАЙХАН

НИЙСЛЭЛ ХОТОД ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛА
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НАРИЙВЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

2019 оны 04 дүгээр сарын 30

№	Хийгдэх үйл ажиллагаа	Хариуцан гүйцэтгэх байгууллага	I				II				III				IV				V				VI				V	
			I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II
ТООЛЛОГЫН БЭЛТГЭЛ ҮЕ БУЮУ 2019 ОНД ХИЙГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА																												
Тооллогын бэлтгэл ажилд хяналт тавих, мэдээлэх, тайлагнах																												
1	Нийслэлийн нутаг дэвсгэрт ХАОСТ-ыг зохион байгуулах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах	Нийслэлийн Статистикийн газар																										
2	Нийслэл, дүүргийн тооллогын комисс, түр товчооны гишүүдийн чиг үүргийг тодорхойлж, ажил үүргийн уялдааг хангах	Нийслэл, дүүргийн тооллогын комисс																										
3	"ХАОСТ-2020 туршилтын тооллого"-ыг нийслэлд сонгогдсон нэгжүүдэд зохион байгуулж, явуулах																											
4	Нийслэл, дүүрэг, хорооны тооллогын түр товчоодын ажлын байрыг бэлтгэж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлж, тохижуулах	Нийслэл, дүүргийн ЗДТГ																										
	а. ХАОСТ-ын материал хүлээн авч шалгах, хадгалах өрөөг бэлтгэх																											
	б. Нийслэл, дүүрэг, хорооны түр товчооны ажлын өрөөний телефон утас, цахилгаан, интернэт сүлжээ, хэвлэх, олшруулах машины найдвартай ажиллагааг хангах зэргээр ажиллах нөхцөлийг бүрдүүлэх																											
5	Нийслэл, дүүрэг, хорооны тооллогын түр товчоодын ажлын байрны галын аюулгүй байдалд хяналт тавих	Нийслэлийн онцгой байдлын газар																										
6	Дүүргийн тооллогын комисс, түр товчооны үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, хамтран ажиллах	Нийслэлийн тооллогын комисс																										

7	Тооллогын бэлтгэл ажлын явц, тулгамдаж буй асуудлын талаарх мэдээллийг Тооллогын улсын комисс, Нийслэлийн тооллогын комисст танилцуулж байх	Нийслэлийн тооллогын түр товчоо																											
8	Тооллогын мэдээлэл цуглуулах үе шатанд хийгдэх ажлын шуурхай төлөвлөгөөг боловсруулан гаргаж, нийслэл, дүүргийн тооллогын комисс, түр товчоодод хүргүүлэх	Нийслэлийн тооллогын комисс																											
	а. БОСТ-2019																												
	б. ХАОСТ-2020																												
ХАӨМС-гийн бүртгэл, мэдээллийг баяжуулах, сайжруулах																													
9	"Хүн ам, өрхийн мэдээллийн сан"-гийн шинэчлэлт, өрх, хүн амын үзүүлэлтүүдийн нөхөлт, мэдээллийн чанар, үнэн бодит байдлыг сайжруулахад байнгын хяналт тавьж, чиглэл, заавар өгч ажиллах	Нийслэл, дүүргийн тооллогын түр товчоо																											
10	Төрийн бусад байгууллагын мэдээллийн сангуудтай тулгалт хийгдсэний дагуу ҮСХ-ноос ирүүлсэн мэдээллийн тодруулгыг чанартай гүйцэтгэж, тогтоосон хугацаанд хүргүүлэх																												
11	“Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-г бүрэн бүрдүүлэх, тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэл хийх ажлыг зохион байгуулах зорилгоор дүүрэг бүрт нэг гэрээт ажилтанг сонгон шалгаруулж, ажиллуулах																												
12	Хорооны нутаг дэвсгэрт оршин сууж буй өрх нэг бүрээр биечлэн орж, хүн ам, орон сууцны мэдээллийг шинэчлэх, “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-г бүрэн бүрдүүлэх чиг үүрэгтэйгээр хороодод ажиллах гэрээт ажилтанг сонгон шалгаруулж, ажиллуулах	Нийслэл, дүүрэг, хорооны тооллогын түр товчоо																											
13	Иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах, бичиг баримтжуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулах	Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, Дүүргийн ЗДТГ																											
14	Хорооны нутаг дэвсгэрт байрладаг эмнэлэг, асрах газар, сувилал зэрэгт байнга оршин суугчдын мэдээллийг урьдчилан гаргуулж, бэлтгэх	Нийслэлийн Эрүүл мэндийн газар																											

15	Нийслэлийн эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа хүн амын мэдээллийн сангийн үнэн бодит байдлыг хангаж, шинэчлэн тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх																												
16	Хорооны нутаг дэвсгэрт байрладаг хорих анги болон хоригдож байгаа болон захиргааны журмаар түр саатуулагдсан иргэдийн мэдээллийг гаргуулж, Нийслэлийн тооллогын комисс, түр товчоонд хүргүүлэх	Нийслэлийн Цагдаагийн газар, Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар																											
17	Хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй халамжийн байгууллагад байнга амьдардаг иргэдийн бүртгэлийг гаргаж, Нийслэлийн тооллогын комисс, түр товчоонд хүргүүлэх	НЗДТГ-ын Нийгмийн Бодлогын хэлтэс																											
18	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдагчдын болон Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийн үнэн бодит байдлыг ханган, шинэчилж, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх	Нийслэлийн Боловсролын газар																											
19	Газрын зураг бэлтгэх, өрхийн цэгийг оновчтой болгох	Нийслэл, дүүрэг, хорооны түр товчоо																											
20	Хорооны хаягийн мэдээллийн сан, хорооны барилга, орон сууцны болон бусад шаардлагатай мэдээллийн сангийн мэдээллийн үнэн бодит байдлыг ханган шинэчилж, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх	Нийслэл, дүүргийн тооллогын комисс, Нийслэлийн Газрын алба																											
21	Тооллогод зориулсан өрх, хүн амын урьдчилсан бүртгэл хийх ажлыг зохион байгуулах /ХАӨМС-гийн баяжилтад анхаарч ажиллах/	Нийслэл, дүүрэг, хорооны тооллогын түр товчоо																											
Тооллогын сургалтыг зохион байгуулах																													
22	Нийслэлийн тооллогын комиссын сургалтыг зохион байгуулах	Нийслэлийн түр товчоо																											
23	Тооллогын сургагч багшийг сонгон шалгаруулах																												

	а. БОСТ-2019																												
	б. ХАОСТ-2020																												
24	Тооллогын сургагч багшийн сургалтыг зохион байгуулах																												
	а. БОСТ-2019																												
	б. ХАОСТ-2020																												
25	Тоологч, шалгагчийн сургалтыг зохион байгуулах	Нийслэл, дүүргийн түр товчоо																											
	а. БОСТ-2019																												
	б. ХАОСТ-2020																												
26	Тоологч, шалгагчийг сонгон шалгаруулж, томилох	Нийслэл, дүүрэг, хорооны түр товчоо																											
	а. БОСТ-2019																												
	б. ХАОСТ-2020																												
27	Нийслэл, дүүргийн тооллогын комиссын дарга, гишүүдээс тооллогын талаар ААНБ, иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах																												
	а. БОСТ-2019																												
	б. ХАОСТ-2020																												
28	ЕБС-ийн сурагчид, их, дээд, мэргэжлийн сургуулийн оюутнуудад ХАОСТ-ын тухай, ХАӨМС-гийн бүртгэлээ онлайнаар хянаж баяжуулахыг уриалан сургалт зохион байгуулах																												
	а. БОСТ-2019																												
	б. ХАОСТ-2020																												
Төсөв, санхүү																													
29	Тооллого зохион байгуулж явуулахтай холбогдон гарах зардлыг орон нутгийн төсөвт тусгуулах арга хэмжээг тухай бүрт нь авах	Нийслэл, дүүргийн тооллогын комисс																											
30	Тооллого явуулах асуулга, заавар, удирдамжийг хороодод хүргүүлэх зардлыг шийдвэрлэх	ҮСХ, Нийслэлийн тооллогын комисс																											
Тооллогын материал хүлээн авч, хуваарилах																													
31	Дүүргийн тооллогын комисст тоологч, шалгагчийн багцыг хуваарилах	Нийслэлийн түр товчоо																											

| | | |

41	Тооллогын төлөвлөлт, зохион байгуулалтыг дахин нягталж эцэслэх	Нийслэлийн тооллогын түр товчоо
42	Тоологч, шалгагч нарт тооллогын үед хариуцан ажиллах өрх, хүн амын мэдээллийг хуваарилах	Нийслэл, дүүргийн тооллогын түр товчоо
ТООЛОХ ҮЕ БУЮУ 2020 ОНД ХИЙГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА		
Тооллогын зохион байгуулалт		
43	Тоолох үеийн шуурхай төлөвлөгөө боловсруулан гаргаж, түүнийг мөрдөж ажиллах	Нийслэлийн тооллогын түр товчоо
44	Нийтийн болон оюутны байр, байшингийн дээвэр, байрны орц, хонгил, дулааны шугам сүлжээний суваг, ой мод, уул хаданд амьдардаг хүмүүсийг тооллогын бэлтгэл ажлын хүрээнд орон нутаг дахь тооллогын түр товчоод бүртгэж, байршлыг тогтоон, тооллогод бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах.	Нийслэл, дүүргийн тооллогын комисс, Нийслэлийн Цагдаагийн газар
45	Тоолох ажилд хяналт тавих	Нийслэл, дүүргийн тооллогын түр товчоо
46	Тооллогын явцын мэдээг хүлээн авч нэгтгэх, мэдээлэх	
47	Урьдчилсан дүнг хүлээн авч нэгтгэх	
ТООЛЛОГЫН ҮЕИЙН ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА		
Тооллогын материал хүлээн авч, нэгтгэх, хүлээлгэн өгөх		
48	Тооллогын материал шалган хүлээн авч, нэгтгэж хүлээлгэн өгөх	Нийслэл, дүүрэг, хорооны тооллогын түр товчоо
49	Тооллогын урьдчилсан дүнг ҮСХ-нд хүргүүлэх	
50	Тооллогын урьдчилсан дүнг шивж оруулах	
51	Тооллогын материалыг багцлах	
52	Тооллогын үйл ажиллагааны тайлан, илтгэх хуудсыг бичих	
Тооллогын мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангах		
53	Нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангах шаардлагатай материалын жагсаалт гаргах	Нийслэлийн тооллогын түр товчоо

54	Архивын асуудал хариуцсан ажилтан томилж ажиллуулах	Нийслэл, дүүргийн тооллогын түр товчоо																											
55	Тооллогын ажилтан мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй байх арга хэмжээг зохион байгуулах																												
ТООЛЛОГЫН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ																													
Хяналтын тооллого																													
56	Сонгогдсон нэгжид тоологдсон иргэдийн мэдээллийг хяналтын тооллогоор нягтлан шалгах	Нийслэлийн тооллогын комисс, түр товчоо																											
57	Хяналтын тооллогын үр дүнгийн тайлан бэлтгэх																												
ТООЛЛОГЫН МЭДЭЭЛЛИЙН САНГ ҮҮСГЭХ, ҮР ДҮНГ ТАРХААХ БУЮУ 2020 ОНЫ 5 ДУГААР САРЫН 01-НЭЭС 2022 ОНЫ 3 САРЫН 1 ХҮРТЭЛ ХИЙГДЭХ АЖИЛ																													
Үр дүн боловсруулалт, тархаалт																													
58	ҮСХ-ноос ирүүлсэн тооллогын үр дүнгийн мэдээллээр нийслэлийн түвшинд үр дүнгийн нэгдсэн тайлан бичих	Нийслэлийн тооллогын комисс, түр товчоо																											
59	Нийслэлийн тооллогын нэгдсэн үр дүнг танилцуулах семинарыг зохион байгуулах	Нийслэлийн тооллогын комисс, түр товчоо																											

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 14-ний өдрийн
А/442 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
НИЙСЛЭЛИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮДИЙН
АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Үйл ажиллагаа	Хийгдэх ажил	Хариуцан ажиллах байгууллага	Хариуцан ажиллах албан тушаалтан
1.Тооллогын бэлтгэл ажлын үед			
Нийслэлийн нутаг дэвсгэрт ХАОСТ-ыг тооллогыг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, журмын дагуу тооллогын ажлыг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах	• Нийслэлийн нутаг дэвсгэрт ХАОСТ-ыг зохион байгуулах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах • Нийслэл, дүүргийн тооллогын комисс, түр товчооны гишүүдийн чиг үүргийг тодорхойлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах. • Тооллогын бэлтгэл ажлын явц, тулгамдаж буй цаг үеийн асуудлын талаарх мэдээллийг Нийслэлийн тооллогын комисст танилцуулан тухай бүрт нь шуурхай арга хэмжээ авч ажиллах. • Тооллогын урьдчилсан бүртгэл буюу “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-гийн шинэчлэлт, мэдээллийн чанар, үнэн бодит байдлыг сайжруулахад байнгын хяналт тавьж, чиглэл, заавар өгч ажиллах • Тооллогод ажиллах түр ажилтнуудыг сонгон шалгаруулж, сургалт зохион байгуулан чадавхжуулсан байна. • Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын сурталчилгааг үе шаттайгаар зохион байгуулж, иргэдийг тооллогод идэвхтэй оролцохыг уриалах. • Тоолох үеийн үйл ажиллагааг зохион байгуулж, цаг үеийн асуудлаар Нийслэлийн тооллогын комисст шуурхай мэдээлж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрт нь авч ажиллах.	Нийслэлийн Статистикийн Газар	Ц.Заяхүү
Харьяа дүүргийнхээ нутаг дэвсгэрт хүн ам, орон сууцны 2020 оны тооллогыг зохион байгуулж, удирдан чиглүүлэх	• Нийслэлийн нутаг дэвсгэрт ХАОСТ-ыг зохион байгуулах үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөний дагуу дүүргийн ХАОСТ-ын төлөвлөгөөг боловсруулж батлуулан, тооллогын бэлтгэл ажлыг хангаж ажиллах. • Дүүрэг, хорооны тооллогын түр товчоодын ажлын байрыг бэлтгэж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлж, тохижуулах. • Дүүрэг, хорооны Тооллогын түр товчоонд шаардагдах бичиг хэрэг, тээвэр, холбоо, тооллогын бэлтгэл ажлын үед ажилласан түр ажилтны цалин урамшуулал гэх мэт нэмэлт зардлуудыг шийдвэрлэх. • Тооллогын урьдчилсан бүртгэл буюу ХАӨМС-гийн шинэчлэлт, мэдээллийн чанар, үнэн бодит байдлыг сайжруулахад онцгой анхаарч,	Дүүргүүдийн тооллогын комисс	

Үйл ажиллагаа	Хийгдэх ажил	Хариуцан ажиллах байгууллага	Хариуцан ажиллах албан тушаалтан
	өрх, иргэн нэг бүрийн мэдээллийг шинэчлэх ажлыг цаг хугацаанд нь бүрэн хийж дууссан байх.		
Нийслэл, дүүрэг, хорооны тооллогын түр товчоодын ажлын байрны галын аюулгүй байдалд хяналт тавих	• Нийслэл, дүүрэг, хорооны тооллогын түр товчоодын ажлын байрны галын аюулгүй байдалд хяналт тавих	Нийслэлийн Онцгой байдлын газар	Ж.Чүлтэмсүрэн 99118061
Иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах	• Иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах, бичиг баримтжуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дүүргүүдийн ЗДТГ-тай хамтран шуурхай зохион байгуулна. • Тооллогын үед нийслэлийн иргэдийн аймаг, дүүрэг хоорондын шилжилт хөдөлгөөний зохицуулалтыг боломжит нөхцөлөөр хийх	Нийслэлийн Бүртгэлийн газар	Г.Анхныбаяр 99908885
Нийслэлийн эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа мэдээллийн сангийн мэдээллийг шинэчлэн, баяжуулах	• Нийслэлийн эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа хүн амын мэдээллийн сангийн үнэн бодит байдлыг хангаж, шинэчлэн тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх • Хорооны нутаг дэвсгэрт байрладаг эмнэлэг, асрах газар, сувилал зэрэгт байнга оршин суугчдын мэдээллийг урьдчилан гаргуулж, Нийслэлийн тооллогын түр товчоонд ируулэх • Иргэдийг тооллогод идэвхтэй оролцохыг уриалсан зар сурталчилгааны материалыг эмнэлэг, эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүдэд байршуулах • Тооллогын ажилтнуудад шаардлагатай үед эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлэх боломжийг бүрдүүлэх	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	Л.Төмөрбаатар 99112755
Боловсролын байгууллагын мэдээллийн сангийн бодит байдлыг хангах	• Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдагчдын болон Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийн үнэн бодит байдлыг ханган, шинэчилж, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх • Иргэдийг тооллогод идэвхтэй оролцохыг уриалсан зар сурталчилгааны материалыг ЕБС, СӨБ-ын байгууллагуудад байршуулах • ЕБС, СӨБ-ын байгууллагуудын багш нарыг тооллогын үед тоологч, шалгагчаар ажиллах боломжийг бүрдүүлж, ХАОСТ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-г мөрдөж ажиллах	Нийслэлийн боловсролын газар	Ж.Гантулга 99117572
Хорооны хаягийн мэдээллийн сан, хорооны барилга, орон сууцны болон бусад шаардлагатай мэдээллийн	• Нийслэл, дүүрэг, хороодын нутаг дэвсгэрийн кадастрын зураг, суурин газрын кадастрын мэдээллийг бэлтгэн өгч, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх	Нийслэлийн Газрын зохион	Э.Болорчулуун 88114499

Үйл ажиллагаа	Хийгдэх ажил	Хариуцан ажиллах байгууллага	Хариуцан ажиллах албан тушаалтан
сангийн мэдээллийн үнэн бодит байдлыг ханган шинэчилж, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх	• Хорооны хаягийн мэдээллийн сан, барилга, орон сууцны болон бусад шаардлагатай мэдээллийн сангийн мэдээллийн үнэн бодит байдлыг ханган шинэчилж, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлж ажиллах	байгуулалтын алба	
Тооллогын ажилтны аюулгүй байдлыг хангах, хорих ангид хоригдож байгаа болон түр саатуулагдсан иргэд, орон гэргүй тэнэмэл иргэдийг тооллогод бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	• Тооллогын үед эргүүлийн ажилтан болон хорооны хэсгийн байцаагч нар тооллогын түр товчооны байр, ажилтнуудын аюулгүй байдлыг хангаж, шат шатны цагдаагийн байгууллагууд тооллогын ажилтнуудад аюулгүйн заавар зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах • Хорооны нутаг дэвсгэрт байрладаг хорих анги болон хоригдож байгаа болон захиргааны журмаар түр саатуулагдсан иргэдийн мэдээллийг гаргуулж, Нийслэлийн тооллогын комисс, түр товчоонд хүргүүлэх • Нийтийн болон оюутны байр, байшингийн дээвэр, байрны орц, хонгил, дулааны шугам сүлжээний суваг, ой мод, уул хаданд амьдардаг хүмүүсийг тооллогын бэлтгэл ажлын хүрээнд орон нутаг дахь тооллогын түр товчоод бүртгэж, байршлыг тогтоон, тооллогод бүрэн хамруулах ажлыг, Нийслэлийн тооллогын түр товчоотой хамтран зохион байгуулах.	Нийслэлийн Цагдаагийн газар	Д.Ядамдорж 80800308
Цаг үеийн шаардлагаар гарсан бусад үйл ажиллагаа	• Тооллогын бэлтгэл ажилтай холбоотой цаг үеийн шаардлагаар гарсан төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил үйлчилгээг чиг үүргийнхээ дагуу хийж хэрэгжүүлнэ.	НЗДТГ, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд	